



2020 ОНЫ  
ЖИЛИЙН ТАЙЛАН

# DARKHAN NEKHII JSC

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

[www.nekhii.mn](http://www.nekhii.mn)



7717-5555

# АГУУЛГА

КОМПАНИЙН ТУХАЙ  
03

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ  
07

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ  
11

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
19

КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ  
21

## Компаний оноосон нэр

Дархан нэхий ХК

## Үйл ажиллагааны чиглэл

Хонины нэхий, ямааны арьс, үхрийн ширээр боловсруулалт хийж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаа, үйлчилгээ

## Компанийн албан ёсны хаяг Холбоо барих

Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн район, Дархан нэхий ХК

Шуудангийн хаяг : Дархан- 213800  
Шуудангийн хайрцаг : 901, Дархан нэхий  
Утас: (976)-77175555  
(976)-70378499  
Факс: (976)-70373149

И-мэйл: info@nekhii.mn  
Веб хуудас: www.nekhii.mn  
Фэйсбүүк: Дархан Нэхий

## Компанийн удирдлага

ТУЗ-ын дарга : Э.Батсайхан  
Ерөнхий захирал : Б.Мягмар-Өлзий

## Үүсгэн байгуулагдсан огноо

1972 он

## Ажилчдын тоо

384

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид олон улсын чанар стандартын түвшинд хүрсэн, зах зээлд өрсөлдөх чадвар сайтай, арьс шир болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг шинэ болон шинэчилсэн технологиор үйлдвэрлэж, дотоод, гадаадын зах зээлд борлуулна.

## ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

Дуурсах нэртэй, дуудах хүчтэй, хамгийн чанартай, хамгийн хямд Монгол бүтээгдэхүүнийг Монголчууд өөрсдөө үйлдвэрлэх

## БИДНИЙ УРИА


Дэвшлийг хэрэгжүүлэгч, Ёс зүйг эрхэмлэгч, Байгальд ээлтэй компани

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна



# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ



ХАНИХ

ТАЙЛАНГАХ

Дотоод аудитын үйл ажиллагаа нь ТУЗ-ийн харъяа Аудитын хороо нь хариуцаж ажиллана.

Дотоод аудит нь байгууллагын эрсдлийн удирдлага, хяналт, засаглалын аливаа үйл ажиллагааны үр өгөөжийг дотоод аудитын мэргэжлийн үүднээс системтэйгээр үнэлж дүгнэн, өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд тусалдаг.

Бүхий л үйл ажиллагаанд чиглэгдсэн байх ба тухайн газар, хэлтэс, салбар, охин компаниудын засаглал, эрсдлийн удирдлага, санхүүгийн хяналтын үр дүнтэй байлгахын тулд бие даасан, бодит байдлаар шинжилсэн, үнэлсэн, зөвөлгөө өгсөн тайлангаар хангана.

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

# ДАРХАН НЭХИЙ ХК

ХҮНИЙ НӨӨЦ, ЦАЛИН ХӨЛС



Нэхий Таннери ХХК

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл



Нэхий Гармент ХХК

Гутал, хувцас оёдлын үйлдвэрлэл



Як Трейд ХХК

Үйлдвэрлэл, худалдаа



Нэхий Трейд ХХК

Сүлжээ дэлгүүр, худалдаа үйлчилгээ



Гранд Як ХХК

Түрээс & Үйлчилгээ



Дэвжих Нэхий ХХК

Зээлийн үйлчилгээ



Нэхий Агр ХХК

Хоол үйлдвэрлэл & Үйлчилгээ



2020 оны хагас жилийн байдлаар 384 ажилтантай үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд **COVID-19** эдийн засгийн энэхүү хүнд цаг үед ажлын байраа хадгалсан.

Жилийн цалингийн дундаж 5.1 % буурсан үзүүлэлтэнд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт 3,4 сард гарсан COVID –н **ОНЦГОЙ НӨХЦӨЛ** байдалтай шууд холбоотой.

# СТАТИСТИК МЭДЭЭ

/2019 оны жилийн гүйцэтгэлтэй харьцуулав /



- 17 %

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО  
16.9 ТЭРБУМ ТӨГРӨГ




- 28 %

ЦЭВЭР АШИГ  
1.7 ТЭРБУМ ТӨГРӨГ



- 83 %

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ  
1.2 ТЭРБУМ ТӨГРӨГ



- 41 %

АРЬС ШИР  
307.8 МЯНГАН ШИРХЭГ



- 34 %

ХУВЦАС  
17.9 МЯНГАН ШИРХЭГ



23 %

ЭЛЭГДЛИЙН ЗАРДАЛ  
1.6 ТЭРБУМ ТӨГРӨГ



- 26 %

ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР  
1.3 ТЭРБУМ ТӨГРӨГ



- 32 %

ТҮҮХИЙ ЭД ТАТАН АВАЛТ  
0.294 САЯ ШИРХЭГ



45 %

ЦҮНХ  
0.753 МЯНГАН ШИРХЭГ



- 10 %

ГУТАЛ  
54.4 МЯНГАН ХОС

## НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО

# 384



ЗАХИРГАА 19%



ҮЙЛДВЭРЛЭЛ 56%



ҮЙЛЧИЛГЭЭ 5%



БОРЛУУЛАЛТ 18%



ХҮҮХЭД АСРАХ  
ЧӨЛӨӨТЭЙ 39



ДОТООДЫН СУРГАЛТЫН  
ТОО 40



ТӨРИЙН ДЭЭД ОДОН  
МЕДАЛЬ 59

## АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА




39%



61%

## АЖИЛТНУУДЫН НАСЖИЛТ



## БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



ДЭЭД - 19%



БҮРЭН ДУНД - 31%



ТУСГАЙ ДУНД - 49%




2020 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН,  
2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үзүүлэлт	2019		2020				2021			
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт		Төлөвлөгөө биелэлт %	Төлөвлөгөө	Өмнөх оноос өсөлт		
				тоо	хувь			тоо	хувь	
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая төгрөг	20,254.73	45,915.21	16,886.25	-3,368.49	-17%	36.78%	34,567.93	17,681.69	105%
Дотоод борлуулалт	сая төгрөг	19,079.00	45,915.21	16,886.25	-2,192.75	-11%	36.78%	34,567.93	17,681.68	105%
ББӨ	сая төгрөг	13,776.30	29,360.00	10,718.19	-3,058.11	-22%	36.51%	15,810.00	5,091.81	48%
<b>НИЙТ АШИГ</b>	<b>сая төгрөг</b>	<b>6,478.43</b>	<b>16,555.21</b>	<b>6,168.06</b>	<b>-310.38</b>	<b>-5%</b>	<b>37.26%</b>	<b>18,757.93</b>	<b>12,589.88</b>	<b>204%</b>
Үйл ажиллагааны зардал	сая төгрөг	4918.46	6,699.00	3,841.93	-1,076.54	-22%	57.35%	11,730.00	7,888.08	205%
Үйл ажиллагааны бус зардал	сая төгрөг	527.143	100.43	1,288.25	761.10	144%	1282.73%	1124.102	-164.15	-13%
Татварын өмнөх ашиг	сая төгрөг	2,613.80	2,915	1,941.74	-672.06	-26%	66.61%	8,000.05	6,058.31	312%
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>сая төгрөг</b>	<b>2,327.63</b>	<b>2,623.50</b>	<b>1,685.93</b>	<b>-641.71</b>	<b>-28%</b>	<b>64.26%</b>	<b>5,468.36</b>	<b>3,782.43</b>	<b>224%</b>
Нийт үйл ажиллагааны зардал	сая төгрөг	5,445.61	6,799.43	5,130.17	-315.44	-6%	75.45%	12,854.10	7,723.93	151%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал		0.27	0.15	0.30	0.03	13%		0.37	0.07	22%



ДУА-ийн өсвөрийн сагсан бөмбөгчдийн аварга шалгаруулах “БАГА ОЛИМП ” тэмцээнийг жил бүр ивээн тэтгэж явуулсаар байна.



Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “СУМО” Бөхийн өсвөрийн аварга шалгаруулах үеэр уригдаж оролцсон хүндэт 12 ахмадууд болох Токио 1964 оны анхны олимпд оролцогчдод хүндэтгэл үзүүлж Бренд бүтээгдэхүүн болон ивээн тэтгэгч байгууллагаар хамтран ажиллав.



Дархан-Уул аймгийн Олон улсын SOS хүүхдийн байгууллагад нийгмийн хариуцлагынхаа хүрээнд шинэ жилийн бэлгээ хүргүүллээ.



Дэлхий дахинд шинэ Коронавирус COVID-19 өвчний халдварын тархалт буурахгүй байгаа энэ хүнд хэцүү цагт Монголын Арьс Ширний Үйлдвэрлэлийн Холбооны санаачлан хэрэгжүүлж буй хандивын хүрээнд болон нийгмийн хариуцлагын хүрээнд хүн ардаа хамгаалах, урьдчилан сэргийлэх үйлсэд тэргүүн эгнээнд ажиллаж байгаа ДУАОК -н Онцгой байдлын газрын алба хаагчиддаа 2000 ширхэг **амны хаалт** компанийн брэнд бүтээгдэхүүн болох 5 хурууны **нэхий бээлий** 100 ширхэг бүхий зүйл хандивлаж, **авран хамгаалах** ариун үйлсэд хувь нэмрээ оруулав.



COVID-19

**Covid-19** вирустэй холбоотой Улсын Онц байдлын үеэр авсан арга хэмжээ: “Гранд Як” ХХК-ийн талбайн түрээсийн төлбөрөө хоёр сараас эхлэн он дуустал 30%-50% хувиар бууруулах шийдвэрийг гаргасан.

Өөрсдийн нөөц боломждоо тааруулан нийт 108 түрээслэгчиддээ 169,512,970 төгрөгний **хөнгөлөлт** үзүүлж Бизнесийн байгууллагынханд үүсч буй хүндрэлийг хохирол багатай хамт даван гарахыг бизнес эрхлэгчдэд компанийн зүгээс уриаллаа.

Дархан Нэхий ХК нь бүхий л үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагаа ухамсарлан бизнесийн үйл ажиллагаагаа ил тодоор явуулж, нийгмийн хариуцлагын өндөр ёс зүйг баримталдаг. Бид хууль, дүрмийг чандлан сахиулан байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүрээлэн буй орчин болон нийгмийн сайн сайханыг чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаас гадна ажилтнуудынхаа ая тухтай, аюулгүй, ажиллах орчинг бүрдүүлж ажиллаж байна.

MNT'000	2018	2019	2020
Ажилтнуудын өмнө хүлээсэн үүрэг	115'848	232'492	123'490
Улсын өмнө хүлээсэн үүрэг	1'687'551	1'684'854	1'212'663
Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг	25'164	28'163	193 '958



Ажилтнуудын өмнө хүлээсэн үүрэг:

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **-46.8 %** -р өссөн



Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг :

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **588 %** -р өссөн



Улсын өмнө хүлээсэн үүрэг:

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **-28 %** өссөн

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА  
НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ  
ТЕХНОЛОГИ  
БҮТЭЭГДЭХҮҮН  
ХӨГЖҮҮЛЭЛТ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ISO 9001 стандарт нэвтрүүлээ

## ISO 9001:2015

Дархан Нэхий ХК-ийн үйлдвэрлэл явуулдаг үндсэн 3 охин компани болох арьс шир боловсруулалтын Нэхий таннери ХХК, нэхий, савхин дээл, арьс ширэн гутал үйлдвэрлэлийн Нэхий гармент ХХК, дизайн боловсруулалт, тусгай захиалгын үйлдвэрлэлийн Як трейд ХХК-иуд үйл ажиллагаандаа ISO 9001:2015 олон улсын чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлээ. ISO 9001:2015 олон улсад зөвшөөрөгдсөн сертификат авах ажиллагаа 2019 оны 9 сард эхэлсэн ба 2020 оны 9-р сарын 3-ны өдөр баталгаажилт хийгдэж гэрчилгээгээ Монгол болон Англи хэл дээр гардан авсан. Сайжруулалтыг байнга тасралтгүй хийхээр зорьж ажиллаж байна.



# ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



## YAKET бренд

Limited edition YAKET шинэ коллекцийн кетнүүд маань 100% цэвэр арьсан, улны хувьд чийг татахгүй, хугарахгүй. 2020 оны 7-р сард нэрийн барааны дэлгүүрүүд болон онлайн худалдаанд гарсан. Залуучууд болон 10-н жилийн сургуулийн хүүхдүүдэд тохиромжтой. Зун болон хавар намартаа өмсөхөд зориулж, өнгөний өргөн сонголттой үйлдвэрлэгдсэн байгаа. Ковидтой холбоотой борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.

**YAKET®**

SIZE  
40 41 42 43

WWW.NEKHII.MN  
WWW.YAKTRADE.MN  
PHONE +976 7717-5555

MADE IN MONGOLIA

**YAKET®**

SIZE  
35 36 37 38 39

WWW.NEKHII.MN  
WWW.YAKTRADE.MN  
PHONE +976 7717-5555

MADE IN MONGOLIA



## YAK Premium leather belt

Арьсан тэлээний судалгааны ажлууд хийгдэж, 2020 оны 10-р сард аралны толгой болон лого батлагдаж захиалга хийгдсэн байгаа. Оны сүүлээр үйлдвэрлэл эхэлсэн ба худалдаанд 2021 оны эхээр гаргахаар ажиллаж байна.

Технологи: Давхар ширтэй битүү суналтаас хамгаалсан наалт болон оёдолтой, аралны толгойг нь татаад эргүүлээд 2 талаараа зүүх боломжтой.

# EAC

ERI	ERI	ERC	ERI	ERI	ERI	ERC	ERC
Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон	Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон	Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон	Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон	Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон	Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон	Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон	Замандаа Монгол Улс Улаанбаатар Хөвсгөл Увс сум Хүтэжээл Тосгон Хүтэжээл Тосгон Увс сум Хүтэжээл Тосгон

ИЛЭГЧИН ЭХЛЭЛТ

Хөвсгөл аймгийн Увс сум Хүтэжээл Тосгон бүсийн 10-р хорооноос

Увс сум Хүтэжээл Тосгон бүсийн 10-р хорооноос

Хүтэжээл Тосгон бүсийн 10-р хорооноос

Увс сум Хүтэжээл Тосгон бүсийн 10-р хорооноос



Хүтэжээл Тосгон бүсийн 10-р хорооноос

Увс сум Хүтэжээл Тосгон бүсийн 10-р хорооноос

## EAC certificate

Евразийн эдийн засгийн холбооны тохирлын гэрчилгээг авахаар 2020 оны 6 сараас эхлэн бичиг баримтын бүдүүлэлт, бараа бүтээгдэхүүний дээжинд шинжилгээ хийгдэж, 2020 оны 11 сарын 11-ний өдөр албан ёсоор баталгаажиж, ДАРХАН НЭХИЙ ХК-ний нэр дээр 8 нэр төрлийн бүтээгдэхүүнд гэрчилгээгээ авсан байгаа. Энэхүү гэрчилгээ нь 5 жилийг хугацаанд ОХУ болон тус гэрчилгээ зөвшөөрөгдсөн холбооны орнуудад экспортоор бараа бүтээгдэхүүн гарган нийлүүлэх тохирлын гэрчилгээтэй болсон.


# ГРАНД ЯК ЗОЧИД БУУДАЛ ҮҮД ХААЛГАА НЭЭЛЭЭ





# GOLDEN YAK LUXURY ДЭЛГҮҮР ҮҮД ХААЛГАА НЭЭЛЭЭ




### БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ



### ТҮҮХИЙ ЭД ТАТАН АВАЛТ




### ЧАНАР






## БОРЛУУЛАЛТ




## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО


- Гадаад борлуулалт
- Оёмол бүтээгдэхүүн
- Гутал
- Арьс шир
- Хүнс
- Үйлчилгээ
- Байр
- Түрээсийн орлого
- Хүүгийн орлого
- Химийн мат борлуулсаны орлого
- Бусад орлого



## ЦЭВЭР АШИГ



## ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ



TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

# САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

MNT'000	2018	2019	2020
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1'140'899.42	458'005.68	582'727.54
Дансны авлага	4'299'745.03	6'254'458.81	5'464'813.60
Бараа материал	12'959'297.47	14'886'578.59	15'111'964.77
Дуусаагүй барилга	6'222'867.91	9'031'467.95	2'393'976.12
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө		3'354'133.76	2'020'302.38
Үндсэн хөрөнгө	28'356'183.13	27'968'307.39	34'317'813.02
Бусад хөрөнгө	2'661'379	1'324'513	743'983
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>55'640'371.96</b>	<b>63'277'465.56</b>	<b>60'635'579.94</b>
Дансны өглөг	1'377'965.73	1'311'720.47	1'433'153.02
Богино хугацаат зээл	4'595'700	7'632'346.51	6'164'458.33
<b>Урт хугацаат зээл</b>	<b>6'250'000</b>	<b>10'295'048.71</b>	<b>7'940'324.54</b>
Урьдчилж орсон орлого	1'585'766.47	3'793'916.12	2'614'471.87
НИЙТ ӨР ТӨЛБӨР	12'223'665.87	19'239'115.68	15'537'935.89
Хуримтлагдсан ашиг	15'242'394.40	13'075'920.62	11'100'750.10
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>43'416'706.09</b>	<b>44'038'349.88</b>	<b>45'097'644.06</b>

# ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

MNT'000	2018	2019	2020
Борлуулалтын орлого	23'023'438	20'254'733	16'886'245
Түрээсийн орлого	29'760	669'038	623'820
Хүүний орлого	620'222	384'452	331'674
Бусад орлого	934'326	537'559	278'720
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>24'607'746</b>	<b>21'845'781</b>	<b>18'120'458</b>
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>1'051'075</b>	<b>2'327'633</b>	<b>1'685'927</b>
Ерөнхий ба удирдлага үйл ажиллагааны зардал	5'378'367.70	4'918'465	3'841'926
Үйлдвэрлэл болон бусад зардал	18'178'303.32	14'599'683	12'592'606
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>23'556'671</b>	<b>19'518'147</b>	<b>16'434'531</b>

# САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

	2015	2016	2017	2018	2019	2020
ROA	2.1%	3.1%	0.9%	2.4%	4.2%	3.2%
ROE	4%	8%	1%	4%	8%	5%
Бие даалтын коэффициент (%)	70.7%	54.8%	78.4%	78.0%	69.6%	74.4%

Борлуулалтын орлогын өсөлт, бууралт (%)	-48.3%	43.1%	33.6%	-15.0%	-12.0%	-16.6%
Үйл ажиллагааны ашгийн өсөлт, бууралт (%)	-65.7%	97.6%	-76.2%	166.6%	97.8%	-26.3%
Эргэлтийн харьцаа	691%	174%	668%	324%	293%	315%

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

# КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн одоогийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгосон.

Ердийн гишүүдэд:

Эрдэнэдалайн Батсайхан  
Равжаагийн Сүмбэнхүү  
Далхжавын Батжаргал  
Хумбагайн Золжаргал  
Баасангийн Гэрэлмаа

Хараат бус гишүүдэд:

Бямбадашийн Мөнхбаяр  
Цэдэвсүрэнгийн Алтангэрэл  
Бат-Очирын Энхнавч  
Цагааны Баттогтох

## Аудитийн хороо

Цэдэвсүрэнгийн Алтангэрэл  
Цагааны Баттогтох  
Бямбадашийн Мөнхбаяр

## Шагнал урамшуулаллын хороо

Хумбагайн Золжаргал  
Бямбадашийн Мөнхбаяр  
Бат-Очирын Энхнавч

## Нэр дэвшүүлэх хороо

Далхжавын Батжаргал  
Цэдэвсүрэнгийн Алтангэрэл  
Бат-Очирын Энхнавч  
Цагааны Баттогтох

# УДИРДЛАГЫН БАГ



Б.МЯГМАР-ӨЛЗИЙ  
Дархан Нэхий ХК  
Гүйцэтгэх захирал



Х.ЗОЛЖАРГАЛ  
Гранд ЯК ХХК  
Гүйцэтгэх захирал



Б.ГЭРЭЛМАА  
Нэхий Трейд ХХК  
Гүйцэтгэх захирал



Г.ГАН-ОЧИР  
Дэвжих Нэхий ХХК  
Гүйцэтгэх захирал



Д.АРИУНСАЙХАН  
Нэхий Агр ХХК  
Гүйцэтгэх захирал



М.ГАНЗОРИГ  
Дархан Нэхий ХК  
Санхүү эрхэлсэн захирал



Б.ЧИНЧУЛУУН  
Дархан Нэхий ХК  
Үйлвэрлэл Хөрөнгө оруулалт  
хариуцсан захирал



С.БАТНАЙРАМДАЛ  
Нэхий Таннери ХХК  
Гүйцэтгэх захирал



М.ШҮРЭНЦЭЦЭГ  
Нэхий Гармент ХХК  
Гүйцэтгэх захирал



М.БАТ-ИРЭЭДҮЙ  
Як Трейд ХХК  
Гүйцэтгэх захирал





Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлын товч мэдээлэл:

- “Дархан нэхий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 03 сарын 21-ны өдрийн 12 цагт Дархан-Уул аймгийн Дархан сумын Үйлдвэрийн районд байрлах “Дархан нэхий” ХК-ийн өөрийн байранд 81,5% хувийн ирцтэй амжилттай зохион байгуулагдлаа.



Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 4 асуудлыг хэлэлцэж баталсан болно. Үүнд:

- Компаний дүрэмд нэмэлт өөрчлөв.
- Дархан нэхий ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав.
- Дархан нэхий Хувьцаат Компанийн хувьцаа хуваах тухай төслийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг дэмжиж батлав.
- ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг болон 2020 оны ТУЗ-ийн нэгдсэн төсвийг тус тус батлав.

# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Дархан Нэхий ХК нь Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд хамаардаг бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ 32.2 тэрбум төгрөгт хүрч Монголын хөрөнгийн биржид хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 20 компаниудад багтдаг.

Дархан нэхий ХК-ийн 2020 оны 03 сарын 21-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар /ирц 81.5%/ хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, арилжааг идэвхжүүлэх, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нарын тоог нэмэгдүүлэх зорилгоор компанийн нэгж хувьцааг 1000 хуваах тухай асуудлыг хэлэлцэн 100% саналаар батлав.

Хувьцаа хуваах төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил дээр "Голомт Капитал" ҮЦК, хуульчийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлж хуулийн дүгнэлт гаргах ажил дээр "Ананд Адвокатс ХНН" хуулийн фирм тус тус хамтран ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 07 сарын 08-ны өдрийн хурлаар Дархан Нэхий ХК-ийн хувьцаа хуваах асуудлыг хэлэлцэж зөвшөөрсөн шийдвэрийг гаргав. Улмаар компанийн хувьцааны арилжааг 2020 оны 07 сарын 9-нээс 08 сарын 02-ны хооронд түр зогсоож, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулан 2020 оны 08 сарын 03-ний өдрөөс эхлэн арилжааг сэргээв.

2020 оны 8-р сараас хойш +29% -иар өсч 2020 оны төгсгөлд 14.88 ₮-т хүрчээ. Энэ нь нэгж хувьцаагаа 1000 хувааснаас хойшхи үзүүлэлт юм.

Zoom 1m 3m 6m YTD 1y All

Nov 1, 2020 → Jan 1, 2021





# ДАРХАН НЭХИЙ

хувьцаат компани

ТӨЛӨӨР АРВИЖИХ МАЛЫН БУЯНГ  
ТҮМЭНДЭЭ ТҮГЭЭХ НЭХИЙ ХУВЬЦАА

НОГДОЛ АШГАА  
ТАРААНА



9001:2015



# ХОЛБОО БАРИХ

WE ARE AT YOUR SERVICE



## БАЙРШИЛ

Дархан-Уул аймаг, Дархан сум,  
Үйлдвэрийн район, Дархан нэхий ХК

Шуудангийн хаяг : Дархан- 213800

Шуудангийн хайрцаг : 901, Дархан  
нэхий



## И-МЭЙЛ

info@nekhii.mn

ficd@nekhii.mn



## УТАС

7717-5555

7037-8499

8804-8903



<http://nekhii.mn/>

<http://yaktrade.mn/>

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

